



TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ЭРХ

Худалдан авагчид зориулав

БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ АШИГЛАХ ЗААВАР

Бараа, бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч байгууллага болон түүний худалдан авагчдын хоорондын богино хугацаанд бараа бүтээгдэхүүнийг зээлээр борлуулснаас үүссэн авлагыг банк санхүүжүүлж, төлбөр тооцоог хариуцаж гүйцэтгэх зориулалт бүхий бүтээгдэхүүн юм.

Давуу талууд:

- Ханган нийлүүлэгч байгууллагаас бараа, бүтээгдэхүүн зээлээр авах шаардлагагүй;
- Бараа, бүтээгдэхүүний төлбөрийг ханган нийлүүлэгчид хугацаандаа төлнө;
- Банкны санхүүжилтийг ашиглах боломжтой;
- Зээлийн хүүний төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа урт;

Зээлийн эрхийн хэмжээ	100.0 сая төгрөг хүртэл
Лимитийн хугацаа	12 сар
Хүүнээс чөлөөлөх хугацаа	45 хоног хүртэл
Хүүнээс чөлөөлөх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд	2% (сарын)
Төлбөр төлөх өдөр	Сар бүрийн 15-ны өдөр
Заавал төлөх төлбөр	Нийт ашигласан зээлийн дүнгийн 20%
Бусад	Зөвхөн Ханган нийлүүлэгчээс худалдан авалт хийнэ

Барьцаа хөрөнгө:

- 50.0 сая төгрөг хүртэл (дансны орлого, бараа материал);
- 50.0 сая төгрөгөөс дээш (нэмэлтээр үл хөдлөх хөрөнгө);

Тавигдах шаардлага:

- Ханган нийлүүлэгч байгууллагатай хамгийн багадаа 1 жил хамтран ажилласан байх;
- Ханган нийлүүлэгч байгууллагаас санал болгосон худалдан авагчдын жагсаалтанд багтсан байх;
- Бусад банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, хүүний өр төлбөргүй, түүхгүй байх;
- ХХБ-нд харилцах данс нээх, дансны гүйлгээ дамжуулах;

Бүрдүүлэх бичиг баримт:

Хуулийн этгээдийн хувьд
• Зээлийн эрхийн хүсэлт (Банкны маягтын дагуу); • Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм (нотариатаар баталгаажсан); • Зээлийн эрх авах болон Барьцаа хөрөнгө барьцаалахыг зөвшөөрсөн талаар тухайн Байгууллагын эрх бүхий этгээд буюу Төлөөлөн Удирдах Зөвлөл, байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол; • Сүүлийн 1 жилийн дансны хуулга; • Бизнесийн үйл ажиллагааг баталгаажуулсан үйл ажиллагааны зураг; • Бусад;

Иргэний хувьд
• Зээлийн эрхийн хүсэлт (Банкны маягтын дагуу); • Иргэний үнэмлэхний хуулбар (нотариатаар баталгаажсан); • Гэрлэлтийн лавлагаа; • Сүүлийн 1 жилийн дансны хуулга; • Бизнесийн үйл ажиллагааг баталгаажуулсан үйл ажиллагааны зураг; • Бусад;

1. ХҮСЭЛТ ГАРГАХ ПРОЦЕСС

Хүсэлт гаргах:

- Ханган нийлүүлэгч талд хүсэлт гаргана;
- Ханган нийлүүлэгч тал Банканд жагсаалтыг хүргүүлнэ;

2. БАНКНЫ СУДАЛГАА:

- Ханган нийлүүлэгчээс зээл хүсэгчийн жагсаалтыг авна;
- Худалдан авагч өөрт ойрхон дурын салбарт хүсэлт гаргана;
- Худалдан авагч тал банканд материал бүрдүүлнэ
- Банк зээлийн судалгааг хийнэ;
- Банк худалдан авагчид зээлийн эрхийг олгоно;

3. БАРАА ХҮЛЭЭН АВАХ:



Анхаарах:


*Зөвхөн нэг Ханган нийлүүлэгч байгууллагаас худалдан авалт хийнэ.

*АТМ-аас бэлэн мөнгө авах болон бусад шилжүүлгийн гүйлгээ хийх боломжгүй байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ АШИГЛАХ ЗААВАР


Та TDBPay ашиглан гүйлгээ хийх бол дараах алхмуудыг гүйцэтгэнэ.

1



Үндсэн нүүр TDBPay хэсгийг сонгоно


2



QR хэсгийг сонгоно

3


QR Дэлгэрэнгүй



Ханган нийлүүлэгчийн TDBPay стикерийг уншуулна


4

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ



Банкнаас олгосон зээлийн эрхтэй кредит дансыг сонгож гүйлгээ хийнэ

5




Гүйлгээ амжилттай хийгдэнэ

Нийлүүлэлтийн сүлжээний зээлийн эрх


Та данс хоорондын шилжүүлгийн гүйлгээ хийх бол дараах алхмуудыг гүйцэтгэнэ

1




Үндсэн нүүр
ГҮЙЛГЭЭ хэсгийг
сонгоно

2



БАНК ДОТОРХ
хэсгийг сонгоно

3



Банкнаас олгосон зээлийн
эрхтэй кредит дансыг сонгож
ханган нийлүүлэгчийн
харилцах дансыг сонгоно

4

Банк доторх гүйлг...



Шилжүүлэх данс

Кредит - 475072805 MNT



Гүйлгээний дүн

250,000.00 ₮



AA Б*

хүлээн авах данс

475072804

илгээх дүн

250,000.00 ₮

гүйлгээний утга

Төлбөр

Гүйлгээ хийх



Мэдээллийг шалган
ГҮЙЛГЭЭ ХИЙХ
хэсгийг дарна

Гүйлгээ амжилттай
хийгдэнэ

5

Банк доторх гүйлг...



Шилжүүлэх данс

Кредит - 475072805 MNT



Гүйлгээ амжилттай хийгдлээ

250,000.00 ₮

ШИЛЖҮҮЛСЭН ДАНС

475072805 MNT

ХҮЛЭЭН АВСАН ДАНС

475072804 MNT

ГҮЙЛГЭЭ ХИЙСЭН ОН САР

2022.01.18 / 16:28

ШИЛЖҮҮЛЭГ

#806400015034

Загвар болгон хадгалах



Гүйлгээг төрлөөр

ангилах

Шилжүүлэг

ГҮЙЛГЭЭНИЙ УТГА

Төлбөр



**TDB ONLINE
АПП-ЫГ TATAХ**

QR Кодыг уншуулж татаж авах боломжтой.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn